



УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ  
ХЭРГИЙН ТАНХИМД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16а,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 16 35,  
Цахим шуудан: vet@vet.gov.mn

2024.02.19 № 041238  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хяналтын гомдол гаргах нь

З.Батсүлдийн нэхэмжлэлтэй, Мал эмнэлгийн ерөнхий газарт холбогдох захиргааны хэргийн хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Мөнхбат миний бие Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 221/МА2024/0046 дугаар магадлалыг эс зөвшөөрч дараах гомдлыг гаргаж байна. Үүнд:

Нэхэмжлэгч З.Батсүлд нь Мал эмнэлгийн ерөнхий газрын хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр буюу тус газрын хууль эрх зүйн асуудлыг дангаар хариуцаж байсан. Хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 6 дугаар хавсралтаар баталсан ба албан тушаалын тодорхойлолтын гол зорилгод хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх, захиргааны акт, гэрээ, баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянах, мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах гэж тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл: байгууллагын эрх бүх албан тушаалтнуудад хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, даргын тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах үүрэгтэй албан тушаалтан нь эцсийн үр дагаврыг даргын өмнө хариуцахаар хуульчилсан буюу энэхүү эрхэлсэн ажил, үүргийнхээ хүрээнд Б/69 дүгээр тушаалын хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, гарсан үр дагаврыг хариуцах үүрэгтэй.

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйл, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр тогтоолын дагуу шилжүүлэн ажиллуулахад ямар нөхцөлд шилжүүлдэг, ямар баримт бичиг үйлддэг, шилжин ажиллах хүсэлтээ гаргах, хоёр байгууллагын хооронд албан бичгээр харилцах зэргийг маш сайн мэдэж байх үүрэгтэй.

Нэхэмжлэгч З.Батсүлд нь эхнэр Ховд аймагт эмнэлэг байгуулсан, эхнэр дээрээ очино, ховдруу шилжмээр байна гэх түүний хүсэл зоргийн дагуу холбогдох тушаал гарсан.

Энэхүү өөрийнхөө /хувийн/ ашиг сонирхлыг нэгт тавьж, өөртөө давуу байдал олгож, төрийн албаны тухай хууль, тогтоомжийг санаатайгаар зөрчиж, эрхэлж буй ажил албан тушаалаа ашиглаж, тушаалаа өөрөө боловсруулсан гэж байгууллагын зүгээс үзэж байна.

Тухайн тушаал ажлын байраар хангах агуулгаар гарсан буюу З.Батсүлдийг Ховд аймгийн Дуут суманд Улсын байцаагчаар томилж, тушаалын хэрэгжилт хангагдсан байдаг.

З.Батсүлд нь тус ажлын байранд ажиллаагүй бөгөөд өөрт ашигтай байдлаар /санаатайгаар/ зориуд нэхэмжлэлээ байнга өөрчилж, гэртээ байж байгаад өндөр цалин хөлсийг сул авна гэсэн хүсэл зорилгогийн үүднээс өөрийн боловсруулсан тушаалын хүрээнд маргасан.


Шүүхээс 3.Батсүлдийн Төрийн албаны тухай хууль, тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйг ноцтой зөрчиж, өөртөө давуу байдал олгон албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ санаатайгаар зөрчиж, хууль зүйн туслалцаа үзүүлэх, хуульд нийцсэн тушаал, шийдвэр гаргах зарчимуудыг зөрчиж, өөрт ашигтай тушаал гаргуулсан үйл баримт /бодит нөхцөл байдал/-ыг үнэн зөвөөр үнэлж дүгнээгүй, тухайн тушаалыг баталсан эрх бүхий албан тушаалтан, байгууллагын даргаас холбогдох гэрчийн мэдүүлэг авах, холбогдох баримт цуглуулах ажиллагааг хийлгүйгээр хэргийг хянан шийдвэрлэсэн. Хэргийг шийдвэрлэхдээ 3.Батсүлдийн тухайн тушаалыг гаргахад оролцсон оролцоо, түүний хүсэл зориг, захиргааны актын хөөн хэлэлцэх хугацаа, хэрэгт хамаарал бүхий нотлох баримтууд зэрэгт тал бүрээс нь бодитойгоор үнэлэлт дүгнэлт өгч шийдвэрлэх учиртай.


Мөн 3.Батсүлд нь маргаан бүхий захиргааны актын талаар гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн байхад түүнийг үндэслэлгүйгээр сэргээсэн нь хууль бус юм.

Хэрэгт 3.Батсүлдийн боловсруулсан тушаалын дагуу түүнд учирсан хохирол болох цалин хөлсийг түүнд олгуулах нь үндэслэлгүй.

Иймд анхан болон давж заалдах шатны шүүх хэргийн нөхцөл байдлыг хоёр өөрөөр дүгнэн хэргийг шийдвэрлэж, шүүх хууль хэрэглээний зөрүү гаргасан, хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтуудыг бүрэн цуглуулалгүй хэргийг шийдвэрлэсэнд гомдолтой байгаа тул Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 221/МА2024/0046 дугаар магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд хэргийг буцааж өгнө үү.

Гомдол гаргасан:

Мал эмнэлгийн ерөнхий газрын ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн, итгэмжлэгдсэн төлөөлөгч:  Д.Мөнхбат



Утас:96002080

Хаяг: БЗД ЗГ-ын 9-р байр. 1-32 тоот

2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр